

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЖАРГАЛАНТ СУМЫН 10 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/168/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh
@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:
Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрэл Хөхийн тэнцвэр аудит ХХК

Аудитор: Д.Хишгээ

Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил... Error! Bookmark not defined.	
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ. ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 978-70433081, Факс: 978-70433081
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН 10 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

2020.02.18 № 2/66
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсрол хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд швардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

• 021020449

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24 891 112.0	35 762 387.0
33	АВЛАГА	34 805.0	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	34 805.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	24 856 307.0	35 762 387.0
351	Түүхий эд материал	-	2 133 200.0
35130	Эм боох материал	-	2 133 200.0
354	Хангамжийн материал	24 856 307.0	33 629 187.0
35410	Бичиг хэргийн материал	-	36 000.0
35420	Аж ахуйн материал	100 000.0	232 000.0
35440	Түлш, шатах тослох материал	1 525 000.0	1 335 000.0
35450	Барилгын засварын материал	-	70 000.0
35460	Хүнсний материал	698 300.0	764 180.0
35470	Бусад хангамжийн материал	22 533 007.0	31 192 007.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	480 122 685.8	471 540 824.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	480 122 685.8	471 540 824.2
392	Биет хөрөнгө	401 412 010.8	392 944 399.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	389 621 309.8	389 621 309.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17 676 829.0)	(33 847 607.6)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50 600 215.0	56 273 415.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33 958 750.0)	(38 674 624.3)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46 776 042.0	50 946 042.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33 949 977.0)	(39 034 927.4)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	8 000 000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(339 208.3)
393	Биет бус хөрөнгө	78 710 675.0	78 596 425.0
39301	Програм хангамж	457 000.0	457 000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(57 125.0)	(171 375.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	78 310 800.0	78 310 800.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	505 013 797.8	507 303 211.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	320 000.0	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	320 000.0	-
413	Өглөг	320 000.0	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	320 000.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	504 693 797.8	507 303 211.2
51	Засгийн газрын хувь оролцоо	504 693 797.8	507 303 211.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	253 704 289.0	253 704 289.0
51101	Өмч: - төрийн	253 704 289.0	253 704 289.0
512	Хуримтлагдсан үр дүн	(61 913 137.0)	(59 303 723.5)
51210	Өмнөх үеийн үр дүн	(61 913 137.0)	(61 913 137.0)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2 609 413.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	312 902 645.8	312 902 645.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	505 013 797.8	507 303 211.2

2.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	348 521 414.0	453 343 200.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14 560 422.0	22 741 200.0
120	Нийтлэг татварын бус орлого	3 988 422.0	22 741 200.0

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3 758 422.0	22 741 200.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2 000 000.0	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	543 420.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1 215 002.0	22 741 200.0
120009	Бусад орлого	230 000.0	-
122	Тусламжийн орлого	3 772 000.0	-
122001	Хандив тусламж /дотоод/	3 772 000.0	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	6 800 000.0	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	6 800 000.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	333 960 992.0	430 602 000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	298 622 500.0	391 385 400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	298 622 500.0	391 385 400.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32 004 700.0	39 216 600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32 004 700.0	-
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	39 216 600.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3 333 792.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3 333 792.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	365 847 446.4	450 733 786.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365 847 446.4	450 733 786.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	362 513 654.4	426 300 091.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215 156 028.0	307 542 644.0
210101	Үндсэн цалин	181 997 172.0	267 155 861.0
210102	Нэмэгдэл	14 817 689.0	11 245 212.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2 560 000.0
210104	Урамшуулал	18 341 167.0	26 581 571.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26 879 718.0	38 979 931.9
210201	Тэтгэврийн даатгал	17 882 777.0	26 689 839.7
210202	Тэтгэмжийн даатгал	2 259 080.0	3 079 626.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 807 264.0	2 463 701.2
210204	Ажилгүйдлийн даатгал	412 436.0	613 342.2
210205	Эрүүл мэндийн даатгал	4 518 161.0	6 133 422.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29 690 228.0	25 208 384.0
210301	Гэрэл, цахилгаан	7 474 308.0	5 045 944.0
210302	Түлш, халаалт	13 497 500.0	10 853 000.0
210303	Цэвэр, бохир ус	8 718 420.0	9 309 440.0
2104	Хангамж, бараа материалын зардал	531 621.0	1 185 650.0
210401	Бичиг хэрэг	336 600.0	525 050.0
210402	Тээвэр, шатахуун	-	92 600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100 021.0	101 000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	95 000.0	12 000.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	455 000.0
2105	Нормативт зардал	48 368 700.0	25 012 820.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	497 250.0
210502	Хоол, хүнс	47 692 600.0	22 959 370.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	676 100.0	1 556 200.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 063 800.0	1 098 700.0
210604	Урсгал засвар	2 063 800.0	1 098 700.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12 528 000.0	432 000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12 096 000.0	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000.0	432 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27 295 559.4	26 839 961.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 063 700.0	414 900.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26 231 859.4	26 425 061.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3 333 792.0	24 433 695.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	3 333 792.0	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3 333 792.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	24 433 695.1
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24 433 695.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(17 326 032.4)</u>	<u>2 609 413.5</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(17 326 032.4)</u>	<u>2 609 413.5</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	343534412.0	430602000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9573420.0	0.0
120	Нийтлэг татварын бус орлого	2773420.0	0.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2543420.0	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.0	0.0
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	543420.0	0.0
120009	Бусад орлого	230000.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	6800000.0	0.0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	6800000.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	333960992.0	430602000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	298622500.0	391385400.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	298622500.0	391385400.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32004700.0	39216600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32004700.0	0.0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.0	39216600.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3333792.0	0.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3333792.0	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	343534412.0	430602000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343534412.0	430602000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	340200620.0	406168304.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215910360.0	307973454.0
210101	Үндсэн цалин	161875700.0	164645380.0
210102	Нэмэгдэл	40190960.0	118276489.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	2794090.0
210104	Урамшуулал	13843700.0	22257495.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26159600.0	38514907.9
210201	Тэтгэврийн даатгал	17681400.0	26066707.9
210202	Тэтгэмжийн даатгал	2200000.0	3087600.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1664500.0	2470000.0

210204	Ажилгүйдлийн даатгал	428200.0	715500.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4185500.0	6175100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30050819.0	26712793.0
210301	Гэрэл, цахилгаан	7474899.0	5045944.0
210302	Түлш, халаалт	13857500.0	12357409.0
210303	Цэвэр, бохир ус	8718420.0	9309440.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3393541.0	1991850.0
210401	Бичиг хэрэг	336600.0	333350.0
210402	Тээвэр, шатахуун	0.0	92600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100021.0	101000.0
210404	Ном, хэвлэл	0.0	70300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2956920.0	1394600.0
2105	Нормативт зардал	49030800.0	27477850.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.0	2723900.0
210502	Хоол, хүнс	48354700.0	23025250.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	676100.0	1728700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2063800.0	1643400.0
210604	Урсгал засвар	2063800.0	1643400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12528000.0	559600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12096000.0	127600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.0	432000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1063700.0	1294450.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1063700.0	1294450.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3333792.0	24433695.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	3333792.0	0.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3333792.0	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	24433695.1
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	24433695.1
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	253 704 289.0	312 902 645.8	(44 587 104.6)	522 019 830.2
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	253 704 289	312 902 645.8	(44 587 104.6)	522 019 830.2
C07	Тайлант үеийн үр дүн			(17 326 032.4)	(17 326 032.4)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	253 704 289.	312 902 645.8	(61 913 137.0)	504 693 797.8
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	253 704 289	312 902 645.8	(61 913 137.0)	504 693 797.8
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	253 704 289	312 902 645.8	(61 913 137.0)	504 693 797.8
D08	Тайлант үеийн үр дүн			2 609 413.5	2 609 413.5
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	253 704 289	312 902 645.8	(59 303 723.5)	507 303 211.2

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	430602000.00	406168304.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	430602000.00	406168304.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430602000.00	406168304.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308753900.00	307973454.00
210101	Үндсэн цалин	184438500.00	164645380.00
210102	Нэмэгдэл	101238800.00	118276489.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2402700.00	2794090.00
210104	Урамшуулал	20673900.00	22257495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41681800.00	38514907.86
210201	Тэтгэврийн даатгал	29331600.00	26066707.86
210202	Тэтгэмжийн даатгал	3087600.00	3087600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2470000.00	2470000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	617500.00	715500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6175100.00	6175100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37573200.00	26712793.00
210301	Гэрэл, цахилгаан	13395900.00	5045944.00
210302	Түлш, халаалт	12300000.00	12357409.00
210303	Цэвэр, бохир ус	11877300.00	9309440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1930900.00	1991850.00
210401	Бичиг хэрэг	123000.00	333350.00
210402	Тээвэр, шатахуун	92600.00	92600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101 000.00	101 000.00
210404	Ном, хэвлэл	70 300.00	70 300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 544 000.00	1 394 600.00
2105	Нормативт зардал	36 960 400.00	27 477 850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2 723 900.00	2 723 900.00
210502	Хоол, хүнс	32 507 800.00	23 025 250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 728 700.00	1 728 700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 643 400.00	1 643 400.00
210604	Урсгал засвар	1 643 400.00	1 643 400.00
2107	Томиллолт, зочны зардал	127 400.00	-
210702	Дотоод албан томиллолт	127 400.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575 600.00	559 600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143 600.00	127 600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000.00	432 000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 355 400.00	1 294 450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 355 400.00	1 294 450.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	430 602 000.00	406 168 304.86
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	391 385 400.00	377 812 111.86
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	391 385 400.00	377 812 111.86
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39 216 600.00	28 356 193.00
132001	Орон нутгийн төсвөөс	39 216 600.00	28 356 193.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	175.00	147.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	175.00	147.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	175.00	147.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант онд нэмэлт дансаар орлого зардлын гүйлгээ хийгдээгүй болно.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шууд захирагч, цэцэрлэгийн эрхлэгч А.Өлзийбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд е баримтын бүрдүүлэлт, унаа, хоол, түлшний хөнгөлөлтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25 -наас 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:

Тус цэцэрлэг нь 2020 онд Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжихэд олон нийтийн оролцоотой эрүүл аюулгүй ээлтэй ногоон орчныг бүрдүүлэн, ёс заншил өв уламжлалаа дээдлэн монгол ёс заншлаар мэндчилэх зөв монгол хүүхдийг төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Үүнд:

- Олон нийтийн оролцоот цэцэрлэг – хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг эх асран хамгаалагч, олон нийтийн оролцоо түншлэлийг өргөжүүлэх,
- Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хүүхэд хамгааллын асуудлаар эцэг эх асран хамгаалагчтай болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран гэрээ байгуулан тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх.
- Хамран сургах тойргийнхоо хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах,
- Багш ажлын байрандаа мэргэжлээрээ тасралтгүй хөгжих, МХТ-ийн чадварыг нэмэгдүүлэн багшийн хандлага ёс зүйг дээшлүүлэх ба хичээл, сургалтын үйл ажиллагаанд багаар хамтран чанартай бэлтгэж багшийн ур чадварыг нэмэгдүүлэх
- “Чадварлаг багш”, “Авъяас”, “Номын гэгээ”, “Хүүхэд бүр цэцэрлэгт” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Эцэг эх олон нийтэд нөлөөллийн ажлыг зохион байгуулж сургалтын үйл ажиллагаандаа татан оролцуулах.
 - Сургалтын байгууллагын орчны аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцүүлэн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*

- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тус байгууллага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна. Тухайн оны шилэн дансны мэдээллээ хугацаандаа оруулж улирал тутам тайлангаа илгээсэн тул зөрчил илрээгүй байна.

Тус цэцэрлэг дотоод хяналтын багтай бөгөөд цэцэрлэгийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, хууль тогтоомжийн хэрэгжилт баримт бичгүүдэд хяналт хийдэг байна.

Сар бүр Жаргалант сумын төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлэхэд 99-100%аар дүгнэгдсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 314737,0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3147,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт/453343.2/ орлогын 2 хувиар 9066.8 мянган төгрөгөөр тооцлоо.

Алдааны дүн материаллаг бус /эрсдэл бага / үр нөлөөгүй цар тахалын үед ажилчидадаа олгосон унаа, хоол, түлшний урамшуулал нь олон хүнийг хамруулсан учраас дүн өндөр гарч буй учраас аудитын төлөвлөлтийн үед сонгосон МБ-түвшинг өөрчлөн 2 хувь болгов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2289.4 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Б	1	2	3=2-1	

Мөнгөн хөрөнгө				
Авлага	34.80		34.80	100.0%
Урьдчилгаа			-	
Бараа материал	24 856.30	35 762.40	- 10 906.10	-43.9%
Үндсэн хөрөнгө	480 122.70	471 540.80	8 581.90	1.8%
Нийт хөрөнгө	505 013.80	507 303.20	- 2 289.40	0.5
Өр төлбөр	320.00		320.00	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	504 693.80	507 303.20	- 2 609.40	-0.5%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	505 013.80	507 303.20	- 2 289.40	-0.5%

Оны эхэнд авлага дансны үлдэгдэл 34.8 мянган төгрөг тайлант онд барагдсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 35762.4 мянган төгрөг болж 10906.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 48150.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 37243.9 мянган төгрөг зарцуулжээ. Хандиваар Тайваны гэр бүлийг дэмжих сангаас 6218.0 мянган төгрөгийн хөнжил гудас, углаа дэвсээ авсан.

Эм боох материалын үлдэгдэл 2133.2 мянган төгрөгийн үлдэгдэл нь Жаргалант сумын Засаг даргын 2020-03-20-ны № 1/288 тоот албан бичиг/Жаргалант сумын ЕБС, СӨБ-ыг гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөцийн жишиг жагсаалт/, 2020-03-13-ны өдрийн Жаргалант сумын онцгой комиссын хурлын шийдвэр № 05 шийдвэрээр эм боох материалын зардал дээр нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Хүнсний материалын үлдэгдэл 36,0 мянган төгрөг байгаа нь МУ-ын боловсрол шинжлэх ухааны сайдын 2020-11-27-ны А/162 тоот тушаалаар тус цэцэрлэг хоол хүнс тэжээлийн дутагдалд өртөх эрсдэл бүхий өөрийн цэцэрлэгт хамрагддаг 7 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн орсон 42524.44 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 382.7 мянган төгрөгийн үнэ бүхий хоол хүнсийг 9 хүүхдэд олгосон байна.

Бичиг хэрэг 36.0, аж ахуйн материал 232.0, түлш, шатах тослох материалын үлдэгдэл 1335.0, барилгын засварын материал 70.0, бусад хангамжийн материал БҮТЭЗ 31192.0 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 471540.8 мянган төгрөг болж 8581.9 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр 1320.0 шкаф, ширээ, хандиваар БСУГ-ын хөрөнгө оруулалтаар 16523.2 мянган төгрөгний тавилга, тоног төхөөрөмж орлого авч данс бүртгэлд тусгасан байна. БСУГ-аас 2 ш нөөтбүүк хөрөнгө оруулалтаар ирснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3499.0 мянган хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдэл оны эхэнд 85642.7 мянган төгрөг байснаас тайлант онд 26425.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна. Тус байгууллага өр төлбөр дансны үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 507303.2 мянган төгрөг болж 2609.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2020-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 104821.7 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 96641.0 мянган төгрөгийн орлого нь өмнөх оноос тусгай зориулалтын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	зөрүү
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	348 521.4	453 343.2	- 104 821.79

ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14 560.4	22 741.2	-	8 180.78
Нийтлэг татварын бус орлого	3 988.4	22 741.2	-	18 752.78
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2 000.0	-	-	2 000.00
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	543.4	-	-	543.42
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1 215.0	22 741.2	-	21 526.20
Бусад орлого	230.0	-	-	230.00
Хандив тусламж /дотоод/	3 772.0	-	-	3 772.00
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	6 800.0	-	-	6 800.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	333 961.0	430 602.0	-	96 641.01
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	298 622.5	391 385.4	-	92 762.90
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32 004.7	-	-	32 004.70
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	39 216.6	-	39 216.60
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3 333.8	-	-	3 333.79

Нийт зардал өмнөх оноос 84886.34 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 92386.2, нийгмийн даатгалын шимтгэл 12100.1, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 4481.8, бараа үйлчилгээний бусад зардал 12096.0, буцаан төвлөрүүлсэн 24333.7 мянган төгрөгөөр тус зардлууд байна.

Энэ нь өмнөх оноос цалин хөлсний зардалд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл шинээр тооцогдон олгогдсон, төсвийн хэмнэлтээс буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	365 847.4	450 733.8	-	84 886.34
УРСГАЛ ЗАРДАЛ	365 847.4	450 733.8	-	84 886.34
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215 156.0	307 542.6	-	92 386.62
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26 879.7	38 979.9	-	12 100.21
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29 690.2	25 208.4	-	4 481.84
Хангамж, бараа материалын зардал	531.6	1 185.7	-	654.03
Нормативт зардал	48 368.7	25 012.8	-	23 355.88
Эд хогшил, урсгал засварын зардал	2 063.8	1 098.7	-	965.10
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12 528.0	432.0	-	12 096.00
Бараа үйлчилгээний бусад зардал	27 295.6	26 840.0	-	455.60
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3 333.8	24 433.7	-	21 099.90
Бусад урсгал шилжүүлэг	3 333.8	-	-	3 333.79
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	24 433.7	-	24 433.70
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24 433.7	-	24 433.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17 326.0)	2 609.4	-	19 935.45
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17 326.0)	2 609.4	-	19 935.45

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан ямар нэгэн өөрчлөлт байхгүй.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 476043.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 476043.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2020 онд хасах тодотгол хийж 45441.0 мянган төгрөгөөр бууруулж 430602.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Коронавируст халдвар/ ковид -19/ цар тахалтай холбоотой анх батлагдсан төсвөөс хасаж тодотгол хийсэн 45441.0 , оны сүүлчээр зарцуулаагүй үлдэгдэл санхүүгийн дэмжлэгээ буцаан төвлөрүүлсэн 24433.7 бүгд 69874.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зарцуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 430602.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 391369.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүгийн дэмжлэгээр, 39216.6 орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 406168.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 406138.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 406168.3 мянган төгрөгийг зарцуулж 24433.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 406168.3 мянган төгрөг буюу 94.3 хувьтай буюу 24433.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	430602.0	406168.3	24433.7
УРСГАЛ ЗАРДАЛ	430602.0	406168.3	24433.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430602.0	406168.3	24433.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308753.9	307973.5	780.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41681.8	38514.9	3166.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37573.2	26712.8	10860.4
Хангамж, бараа материалын зардал	1930.9	1991.9	-60.9
Нормативт зардал	36960.4	27477.9	9482.6
Эд хогшил, урсгал засварын зардал	1643.4	1643.4	0.0
Томилонт, зочны зардал	127.4	0.0	127.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575.6	559.6	16.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1355.4	1294.5	61.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	430602.0	406168.3	24433.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	391385.4	377812.1	13573.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39216.6	28356.2	10860.4

- ✚ Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 780.4 мянган төгрөгөөр хэмнэсэн нь тухайн онд ковид-19 буюу цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа хэдэн сараар хүүхэд авахгүй хойшилсон, энэ үед багш, туслах багш нарын илүү цагийн хөлс олгоогүй, жирэмсэн болон хүүхдээ асарч байгаа багшийн оронд түр ажиллаж байсан багшийг амрааж цалинг хэмнэсэн зэргээс шалтгаалжээ.
- ✚ Оны эцэст Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 28.3 хувь буюу 7437.3 мянган төгрөгийг түлшний хөнгөлөлтөд олгосон байна.
- ✚ Нийгмийн даатгалын шимтгэл:3166.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь анх төсөв төлөвлөхдөө нэг хувийн илүү тооцоололт хийгдсэн тул тухайн санд үлдээн буцаан төвлөрүүлсэн байна.

- ✚ Байр ашиглалттай холбоотой зардал 10860.4, Хоол хүнс 9482.6, дотоод томилолт 127.4, бараа үйлчилгээний бусад зардал 61.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Ковид-19 буюу цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн үйл ажиллагаа зарим сард ажиллаагүй, зарим сард хагас ажилласан, тайлант онд томилолтоор багш ажилтан яваагүй, зуны улиралд ээлжийн бүлэг ажиллаагүй зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын нэмэлт дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар НББ-ийн бодлогын баримт бичиг өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулах зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8260.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 543.6 мянган төгрөгний алдаанд төлбөрийн акт, 7717.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 543.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Үр дүнгийн урамшуулалыг илүү олгосон, багш ажилчид цэцэрлэгийн хүүхдийн нэрс, аньс, чацаргана, аарц хэрэглэсэн нийт 543608 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 заалт, үнэн зөв, иж бүрэнбайх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов:

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 7717.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараах 2 асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангийн үеэр анхаарал хандуулж дахин хянаж хэрэгжилтийг нэгтгэн хянах шаардлагатай байна. Үүнд:

- 2020-09-03-ны өдрийн А/483 тоот Ховд аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн анги танхим байрны дотоод орчны агаарын чанарыг сайжруулан дэвшилтэт технологи болох “Окфил” агаар шүүгчийг суулгах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус цэцэрлэгт 15 ширхгийг 3 ангид 1695.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн,
- 2020 оны 02 сарын 18-ны Ховд аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай захирамжаар Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 380.0 мянган төгрөгийн маск нийлүүлэх гэрээ хийж Буянт үйлийн шим ХХК-д шилжүүлсэн
- БСУГ-аас хөрөнгө оруулалтаар Dell latitude 3400 CTO Business model 2 ширхэг нөтөбүүкийг нэг бүрийг 1749500 төгрөгөөр 3499,0 төгрөгөөр бэлтгэсэн зэрэг асуудлуудыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангаар авч үзэх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. И-баримтын бүрдүүлэлт

1.1. *Илрүүлэлт:* Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу байна.

1.2. *Эрсдэл:* тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. *Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Зөвшөөрсөн

Цалингийн зардал /хоол, унаа, түлшний хөнгөлөлт/

3.1. *Илрүүлэлт:* Оны эцэст Коронавируст халдвар ковид-19-ын цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 7437.3 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 26 албан хаагчдад олгосон байна. Мөн түр ажилтан 4 сар ажилласан байхад оны эцэст түлшний хөнгөлөлт олгосон зэрэг зөрчлүүд гаргаж цалингийн зардлыг үрэлгэн зарцуулсан байна.

3.2. *Эрсдэл:* төсвийн хөрөнгийг буруу зарцуулах, эдийн засгийн ангилал зөрчих, төсвийн төлөвлөлт буруу төлөвлөх

3.3. *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах

3.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/168/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бусдад өгөх тооцоог илүү тооцож олгосон	543.6	Акт	Захирал	А.Өлзийбаяр
2	Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу	0	Зөвлөмж	Захирал	А.Өлзийбаяр
3	Батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 7437300 мянган төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 26 албан хаагчдад олгосон байна. Түр ажилтанд 4 сар ажилласан байхад оны эцэст түлшний хөнгөлөлт олгосон	7717.3	Зөвлөмж	Захирал	А.Өлзийбаяр
ДҮН		8260.9			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР Огноо:2021. 02.18

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН Огноо:2021.02.18

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-НЫ ХОВД АЙМАГ ДАХЬ
САЛБАРЫН ЗАХИРАЛ, АУДИТОР Д.ХИШГЭЭ

Огноо:2021. 02.18

